



Г ЗАРИМ БАЙГУУЛЛАГУУДАД

МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас: 32-63-67, Факс: (976-11) 31-13-81,
<http://www.mmhi.gov.mn>

2020. 11.18 № 01/2863
танай -ны № -т


Г Улсын Онцгой комиссын
шийдвэрийн хэрэгжилтийг
хангах тухай

Коронавирусын тархалтын гадаад, дотоод нөхцөл байдлаас шалтгаалан Засгийн газар, Улсын Онцгой комиссын шийдвэрээр Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх шийдвэрийг гаргасан.

Улсын Онцгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 35 дугаар хуралдааны тэмдэглэлээр Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эрчим хүчийг найдвартай хангах үүрэг бүхий нүүрсний уурхай, экспортын голлох ашигт малтмалыг олборлогч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах хүрээнд сэлбэг хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, бараа, материалыг төв, орон нутгийн замд саадгүй явуулах арга хэмжээ авч ажиллахыг холбогдох байгууллагуудад даалгасныг хавсралтаар хүргүүлж байна.

Иймд улс орны эдийн засгийн тогтвортой байдлыг хангах үүднээс холбогдох хууль, журам, тогтоосон дэглэмийн хүрээнд уул уурхайн салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын хэвийн ажиллагааг хангах зорилгоор ханган нийлүүлэлтийн ачаа тээвэрлэлтийг төв, орон нутгийн замд саадгүй нэвтрүүлэх ажлыг шуурхай зохион байгуулж, Улсын Онцгой комиссын шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг хүсье.

Хавсралт хуудастай.





УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 онд 4 сарын 15-ны өдөр

Дугаар 25

Ч.Дамдинцээрэг

XXXV ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын XXXIV дугаар хурал 2020 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 11:00 цагт Төрийн ордон дахь Шадар сайдын ажлын врөөнд 97 хувийн иртэй хуралдав

Хурлыг Монгол Улсын Шадар сайд Улсын онцгой комиссын дарга Я Содбаатар даргалж, холбогдох шийдвэр гаргаж, үүрэг даалгаврыг өгөв

ХЭЛЭЛЦСЭН НЬ.

1. Эрүүл мэндийн яамны мэдээлэл (Коронавируст халдварт /Ковид19/ хүн амын дунд бүртгэгдсэн байдал, дэгэлтийн цар хүрээ, зэрдэлийн үзүүлэлтэй);

Эрүүл мэндийн сайс
Улсын онцгой комиссын гишүүн Т.Мөнхсайхан

2. Гамшигаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай;

Улсын онцгой комиссын орлогч дарга,
Онцгой байдлын ерөнхий газрын дарга
бригадын генерал Г.Ариунбүун

3. Застгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 176 дугаар тогтоолоор бүх нийтийн бэлэн байдагд шилжүүлсэн нацелт байдлын үед газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах, неец бүрдүүлэхээс холбоотой авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээ болон уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт тээвэрлэлт, экспорт тус бус нутгийн халдварт хамгааллын дэслэгмийг чангатгах талаар;

Үүл уурхай, хүнд үйлдвэрийн сайс
Улсын онцгой комиссын гишүүн Г.Енбек

4. Бусад

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг Засгийн газрын Хэрэг зөрхлөх газрын Тэргүүн дэд дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Б.Ганбат,

Улсын онцгой комиссын орлогч дарга,
Онцгой байдлын ерөнхий газрын дарга,
Бригадын генерал Г.Ариунбаян нарт

1.1. Засгийн газрын 2020 оны 178 дугаар тогтоослын 1 дэх хэсэгт заасан гамшигас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 06:00 цагаас 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 06:00 цаг хүртэл хугацаанд сунгах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхээр тогтов.

Хоёр. Эруул мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Т.Мөнхсайхан,
Боловсрол, цинжэлх ухааны сайд Л.Цэдэвсүрэн,

Цагдаагийн ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, Цагдаагийн хурандаа Ж.Болд,
Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Т.Гантулга,
Эруул мэндийн улсын албаны шуурхай штабт:

2.1. Коронавируст халдвартын **КОВИД-19**-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээний оперативийн цагийн төлөвлөгөөг боловсруулах, хүч хэрэгсэл, нэн швардлагатай неецийн тооцоо, дайчилгав, нуулгэн шилжүүлэх төлөвлөгөөг салбар бүрзэр тодотгох, нэгдсэн төлөвлөгөөг нэхцэл байдалтай уялдуулан дахин боловсруулж батлуулах;

2.2. Ууссан цагийн байдалтай уялдуулан хүч хэрэгслийн тооцоо, алба хвагчдын ажиллах хуваарь, неецийн оновчтой тооцоо, "Онц байдал" зарласан тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж (тодотгох), бэлтгэл бэлэн байдлыг дээшлүүлэх;

2.3. Нэхцэл байдал, хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талварт мэдээ, мэдээлэл солилцох, дээд шатны байгууллага, албан тушаалтны шийдвэр, үүрэг, чиглэлийг шуурхай мэдээлэх салбар хоорондын мэдээлэл солилцох механизмыг оновчтой болгох, мэдээллийн аюулгүй байдлыг хангах;

2.4. Гамшигас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийг 2020 оны 11 дүгээр сарын 17-ний өдрөөс 12 дугаар сарын 18-ны өдрийт хүртэл

цахим халбэрээр зохион байгуулах асуудлыг судлан зохих шийдвэр гарган хэрэгжүүлэх;

2.5. Улаанбаатар хотод албан томилот, сургалт, өрүүл мэндийн үйлчилгээ авах, хувийн хүндэтгэх шалтгаанвар ирсан иргэдийг шинжилгээнд хамруулж, орон нутагт нь буцаах боломжийг судлан шийдвэрлэх;

2.6. Эрүүл мэндийн улсын албаны шуурхай штабын бүрэлдэхүүнд холбогдох байгууллагуудын шийдвэр гаргах эрх бүхий албан тушвалтан, мэргэжлийн алба хавгчдыг томилгоожуулж, чиг үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, баталгаажуулах;

2.7. Эмнэлгийн байгууллагын эмч, эмнэлгийн ажилтан, голомттой бүс нутгаас иргэдийг тээвэрлэн авч ирсэн болон нэн зэрэлтэй нэхцелд ажиллаж байгаа ажилтан, албан хаагчдын эрүүл мэнд, аюулгүй байдалд онцгой анхаарах, халдвэр хамгааллын дэглэмийг чанд мэrdүүлж ажиллах;

2.8. Тусгаарлах, ажиглах байранд цар тахлын халдвартын үед тусгаарлах ажиглах журмыг чвнд сахиулах, тусгаарлах байрны орчин нэхцэл, үйл ажиллагааг сайкруулах, ариутгал халдвартгүйжүүлэлтийг тогтолцоулж зохион байгуулж байх;

2.9. Коронавируст халдвэр /Ковид-19/-аар нас баралт бүртгэгдсэн тохиолдолд цогцос чандарлах асуудлыг шийдвэрлэх, төлөвлөгөөнд тусгах.

2.10. Коронавируст халдвэр /Ковид-19/-ын үед эмнэлгийн хог хаягдлыг "Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устах журам"-ын дагуу устах ажлыг зохион байгуулж, халдвэр хамгааллын дэглэмийн хяналтыг сайжруулах;

2.11. Тусгаарлах байруудад хийсэн хяналт, шалгалтын дүнг 2020 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн дотор танилцуулах;

Гурав. Зам, тээврийн хөгжлийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Л.Халтар.

Уул уурхай, хунд үйлдвэрийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Г.Ендон.

Зэрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Т.Мөнхсайхан.

Хөдөлмөр, нийгэм хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Г.Өнөрбаяр.

Улсын онцгой комиссын орлогч дарга,
Онцгой байдлын ерөнхий газрын дарга,
Бригадын генерал Г.Ариунбуян.

Хил хамгаалах өрөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал Ж.Бямбасүрэн,

Цагдаагийн өрөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Ж.Болд,

Гавлийн өрөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Асралт,

Мэргэжлийн хяналтын өрөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Т.Гантулга,

Ашигт малтиал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн,

Улаанбаатар темер замын дарга Д.Жигжиднямаа,

Аймаг, нийслэлийн Засаг дарга, Онцгой комиссын дарга наарт,

Газрын тосны бутээгдэхүүний худалдаа эрхлэг ААН-үүдэд,

Үүл уурхайн голлох бутээгдэхүүн экспортлогч,

Эрчим хүчиний нуурс олборлогч ААН-үүдэд;

3.1. Газрын тосны бутээгдэхүүн / автобензин, дизель түлш, шатдаг хий, тос тослогооны материал г.м/ -ий тасалдал, хөмсдол үүсэхээс сэргийлэх зорилгоор тэмер замын Сүхбаатар, Замын-Үүд, Эрзэнцав боомтуудаар импортоор орж ирж буй бүх бутээгдэхүүний хил нэвтрүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай зохион байгуулах, халдварт хамгааллын дэглэмийг чанд мөрдөхийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад чиглэл болгох;

3.2. Ус аймаг дахь Боршоо авто замын боомтын цаана гацсан тээврийн хэрэгслийг наг удав татаж авах всуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах талаар судалж танилцуулах;

3.3. Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд газрын тосны бутээгдэхүүний /бүх төрлийн автобензин, дизель түлш, шатдаг хий, тос тослогооны материал г.м/ хангамжийг тогтвортой байлгах ажлын хүрээнд тэдгээрийн тээвэрлэлт, түгээлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу аймаг, нийслэл, орон нутагт саадгүй нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;

3.4 Эрчим хүчиний нуурсээр тасралтгүй найдвартай хангах, аюулгүйн неэцийг бүрдүүлэх үүрэг бүхий нуурсний уурхайнууд, экспортын голлох ашигт малтиал олборлогч ААН-үүдийн үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулахад шаардлагатай арга хэмжээг авах;

3.5 Уул уурхайн олборлогч ААН-үүдийн ажилтан албан хаагчдын эрүүл мэнд, аюулгүй байдалд онцгой анхаарч халдварт хамгаалалтын дэглэмийг чанд мөрдүүлж, эрүүл мэндийн үзлэг, оношлогоонд хамрагдсан ажилчдыг зэлж солих.

шилжилт хөдөлгөөн хийхтэй холбогдох асуудлыг хууль тогтоомж, заавар зөвлөмөкид нийцүүлэн шийдвэрлэх, холбогдох зардлыг ААН-үүдэд хариуцуулах;

3.6 Уул уурхайн зориулалттай сэлбэг хэрэгсэл, техник тоног төхөөрөмж тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл баава материалын тээвэрлэлт, түгээлтийг халдвар хамгааллын дэглэмийт сайтар мөрдөж, ариутгал, халдвартгүйжүүлэн холбогдох хууль тогтоомжийн дагуу аймаг, нийслэл, орон нутагт саадгүй нэвтрүүлах;

Дөрөв. Зям. тээврийн хөгжлийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Л.Халтар.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Г.Ендон.

Улсын онцгой комиссын орлогч дарга,
Онцгой байдлын ерөнхий газрын дарга,
Бригадын генерал Г.Аруунбуян.

Хил хамгаалех ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал Ж.Бямбасурэн.

Цагдаагийн ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандав Ж.Болд.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Т.Гантулга.

Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн С.Энхтувшин нарт.

4.1. Авто замын шалган нэвтрүүлэх товчоо, цэгүүдэд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, мэдээлтээр хангах, зөвхөөрөгдсөн чиглэлээр хөдөлгөөн үйлдэж байгаа иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад хүндрэл, чирэгдэл учруулахгүйгээр хязгварлалтын дэглэмийг сахиулах;

4.2. Хүнсний гол изрийн бутаагдажхүүний наец, хангамж, нийлүүлэлтийн хэвийн ўл ажиллагааг хангаж, орон нутгаас орж ирж байгаа болон нийслэлээс гарч байгаа хүнсний тээвэрлэлтийг саадгүй нэвтрүүлэх, унийн тогтвортой байдлыг хангах, хяналт шалгалтыг чангаттаж ажиллах;

4.3. Цаг уур, орчны шинжилгээний газраас Дэлхийн цаг уурын байгууллагын бүсийн төвүүдэд байгалийн гамишиг, осол, хүн, малын гоц халдварт өвчин тархалтын үед "Цаг уурын ажиглалтын мэдээ"-г 3 цаг тутамд мэдээлдэг тул тус байгууллагыг бүх нийтийн балан байдлын зэрэгт шилжүүлсэн үед хэвийн ажиллах боломжоор хангаж, авто замын пост, хяналтын цэгээр бичигт баримтыг шалган саадгүй нэвтрүүлж байх;

4.4. Коронавируст халдварт /Ковид-19/-ын голомтын бүсэд үүрэг түйцэтгэж байгаа алба хаагчдыг хүн нэг бүрийн хамгаалах хувцас, хэрэгслээр хангаж, ашиглах зааварчилгаа өгөх. Хүйтний улирлын хувцас өмсеж байгаатай холбогдуулан хамгаалах хувцасны төрөл, хэмжээ, цаг агаарын нахцелтэй уялдсан байх талаар анхаарах илчлэг, дархлаа дэмжих хоол, хүнс, унаагаар хангах.

4.5. Хот, суурин газрын дотор коронавируст халдварт /Ковид-19/-ын эрдэл өндөр бүхий объект, худалдаа үйлчилгээний байгууллагууд, гудамж, талбайд ариутгал, халдвартүйжүүлтийн арга хэмжээг зохион байгуулах, голомт бүхий нийслэл, аймгуудаас гарч байгаа автомашин тээврийн хэрэгслэд ариутгал халдвартүйжүүлэлтийг заавал хийх халдварт хамгааллын дэглэмийг чанд сахиулах.

4.6. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үеийн Эрчим хүч, дулаан, цахилгаан, усан хангамж мэдээлэл технологийн хэвийн үйл ажиллагааг хангах, шаардлагатай неөцийг бүрдүүлж бэлэн байдлыг хангуулах;

Таё. Улсын онцгой комиссын тишүүд.

Аймаг, нийслэлийн Онцгой комиссын дарга нарт.

5.1. "Коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх серег нөлөөллийг бууруулах тухай хууль"-ийн хүрээнд батлагдаагүй байгаа журмуудыг нэн яарлтай батлан, хэрэгжилтийг хангаж ажиллах;

5.2. Хууль тогтоомж, шийдвэрийг зөрчсөн байгууллага, албан тушаалтан, хувь хүн, хуулийн этгээдэд Коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх серег нөлөөллийг бууруулах тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль Төрийн албаны тухай хуулийн дагуу хариуслага тооцох арга хэмжээг тухай бүр шуурхай авч хэрэгжүүлэх, энэ талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх;

5.3. Аймаг хоорондын тээврийн шалган нэвтрүүлэх төвчоо хяналтын цэгүүдээр ёс тэжээл, тулээ, түлшийг зөөврөлх тээврийн хэрэгслэл жолоочийг халдварт хамгааллын дэглэмийг чанд сахиуулж, шуурхай, саадгүй нэвтрүүлэх;

5.4. Эрүүл мэндийн улсын албаны шуурхай штабыг шаардлагатай мэдээ мэдээллээр хангаж, ажлын уялдаа холбоог хангах;

Зургаа. Улсын онцгой комиссын орлогч дарга,

Онцгой байдлын өронхий газрын дарга,

Бонгадын генерал Г.Ариунбуян,

Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга,

Хурандас П.Батав нарт.

6.1. Засгийн газрын болон Улсын онцгой комиссын хуралдааныг цахим хэлбэрээр хуралдуулах тухай журмын төслийг боловсруулж Улсын онцгой комисст танилцуулах;

Долоо. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга,

Улсын онцгой комиссын тишиун Б.Болор-Эрдэнэд;

7.1 Олон улсад хэрэглэж байгаа мэдээлэл технологийн ололт амжилтыг нэвтрүүлэх, аппликацийн, программыг нэн яяралтай хөгжүүлж балэн болгох;

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД,
УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА

СОДБААТАР

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИИН БИЧГИЙН ДАРГА,
ДЭД ХУРАНДАА

Т.МӨНХДОРЖ